



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 03

Айрагийн энгэр

**Сум, суурин газрын
өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай**

Хэнтий аймгийн хэмжээнд 2025-2026 оны өвөлжитийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.16 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5, 25.1.12 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.3, 30.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь

Нэг.Засаг даргын орлогч, төсвийн шууд захирагч нарт:

1.1.Төрийн байгууллагуудын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэлийг шалгаж, цаг агаарын эрс хүйтрэл, байгалийн гамшиг, учирч болзошгүй эрсдэл, хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулах, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллах

1.2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын модны хуваарь баталсан тогтоол шийдвэрийг үндэслэн мод бэлтгэх эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ойн нөхөрлөлийн хуваарьт цэвэрлэгээний ажлыг зохих журмын дагуу гүйцэтгүүлэх, иргэдийн ахуйн хэрэгцээний түлээг хангах ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулж уг ажилд байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчдын тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тооцох

1.3.Сум, хот, тосгоны төвийн дулаан хангамж, гүний худаг, усан сангуудад урсгал засварыг чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах

1.4.Халаалтын хугацааны нүүрсний үнс, хаягдал, модны үртсийг тээвэрлэн талбайг цэвэрлэж, 2025-2026 оны өвлийн улиралд шаардагдах түлээ, нүүрсийг татан авах гэрээг түлээ нүүрсээр хангагч байгууллага, иргэдтэй 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор байгуулж, шаардлагатай нөөц бүрдүүлэх

1.5. Дулаан хэрэглэгч байгууллагууд(төсвийн) өөрсдийн эзэмшлийн шугам сүлжээнд урсгал засвар хийх, дулаан хүлээн авах бэлтгэлийг хангах, төсвийн шууд захирагч нар батлагдсан төсөвт багтаан төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж ажиллах

1.6. Ус, дулаан хэрэглэгч албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд өөрсдийн эзэмшлийн ус, дулааны гадна худгийг халаалтын улирлаас өмнө заавал цэвэрлэх, хангагч байгууллагын тавьсан шаардлагыг биелүүлэх, байшин, барилгын цонх, хаалга, хана, хучилтын дулаан алдагдлыг арилгах болон хангагч байгууллагатай үйлчилгээний төлбөрийн асуудлыг шийдвэрлэж урьд онуудын өрийг барагдуулах

1.7. 2025-2026 оны халаалтын улиралд шаардагдах түлээ нүүрсний 50-иас доошгүй хувийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор татан нөөцлөн, төлөвлөгөө гарган ажиллах

1.8. Сумдад суурилагдсан дизель станцын техникийн бэлэн байдлыг хангаж, аваар ослын үед ажиллах бэлтгэлтэй байх, эрчим хүчээр хангах схемийг боловсруулж, ажиллах хүчний бэлэн байдлыг хангах

1.9. Дулаанаар хангагч байгууллагын хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор тухайн оны 11 дүгээр сарын 01-ээс дараа оны 3 дугаар сарын 01-ийг хүртэлх хугацаанд дулааны шугамаас огтолцоо авахгүй байх, сүлжээнд шинээр хэрэглэгч холбохгүй байх, аваар болон ослын бус шалтгаанаар дулаан хангамжийн ажиллагааг зогсоохгүй байх

1.10. Улсын болон орон нутгийн төсвийн харангаар хийгдэж байгаа дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын зэрэг инженерийн шугам сүлжээний ажлуудыг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны дотор зураг төсөл, норм дүрмийн дагуу хийлгэж дуусгах шаардлага тавьж, ажлын явцын мэдээллийг тогтмол шуурхай аймгийн удирдлагад мэдээлж байх

Хоёр. Өмнөдэлгэр илч ХХК-ийн захиралд:

2.1. Өөрсдийн эзэмшил, ашиглалтад байгаа сум, суурин газрын дулаан хангамж, усан хангамж, худаг, насос, станцуудыг засварлах, техникийн үйлчилгээг тогтмол хийж, өвлийн улиралд найдвартай ажиллах бэлтгэлийг хангах

2.2. Халаалтын хугацааны нүүрсний үнс, хаягдлыг тээвэрлэн талбайг цэвэрлэж, 2025-2026 оны өвлийн улиралд шаардагдах нүүрсийг татан авах гэрээг нүүрсээр хангагч байгууллагатай 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор байгуулж халаалтын улирал эхлэхэд зохих нөөцийг бүрдүүлэх

2.3.Усан халаатын зуух, шугам сүлжээ насос, үлээх сорох тоноглол, хянах багаж хэрэгсэл, үнс баригч, хэмжих хэрэгслүүд, шугамын засвар үйлчилгээний графикийг объект нэг бүрээр гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

2.4.Халаалтын улиралд гаднах агаарын температураас хамааралтайгаар хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй, жигд, батлагдсан температурын графикийн дагуу, технологийн горимыг барьж ажиллах

2.5.Дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын системийн саатал, ослын үед ажиллах багийг бэлэн байдалд байлгах, ажилчдыг чадавхжуулах, гэмтэл саатлыг арилгах талаар авч байгаа арга хэмжээг тогтмол шуурхай Эрчим хүчний зохиуцуулах зөвлөлд мэдээлж байх

2.6.Усан халаалтын зуухны яндангаар гарч байгаа утааны бохирдлыг хэмжих зорилгоор янданд цорго гаргаж хэмжилт хийх нөхцөл боломжоор хангах

2.7.Гарч болзошгүй, аваар ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүй нөөцийг бүрдүүлж, ослын үед ажиллах аваарын багийг бэлэн байдалд байлгах,

2.8.Цахилгаан эрчим хүч доголдсон тохиолдолд зуухны хэвийн үйл ажиллагаа алдагдаж, барилга байгууламжийн халаах хэрэгсэл, шугам сүлжээ хөлдөх эрсдэлээс урьдчилан сэргийлж, дулаанаар хангагч байгууллагууд өөрсдийн хүчин чадалд тохирох нөөц дизель генераторыг бэлэн байлгах, байхгүй бол нэмж суурилуулалт хийсэн байх, генераторыг автомат удирдлагад холбож 7-14 хоногийн дизель түлш нөөцлөх,

2.9.Нэмэлт ус, сүлжээний усны эх үүсвэрүүдийн найдвартай байдлыг хангаж дулаалга битүүмжийг сайжруулж, цахилгааны холболтыг автомат удирдлагад холбох

2.10.Ашиг олох зорилгоор усыг үйлдвэр үйлчилгээнд ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу усны дүгнэлт, гэрээгээ 2025 оны 9 дүгээр сарын 15-ны дотор байгуулах

Гурав.Цахилгаан эрчим хүч, холбоогоор хангагч байгууллагуудад:


3.1.Өмнөдэлгэр сумын нутаг дэвсгэр дэх өөрийн харьяаллын цахилгаан, холбооны дамжуулах, түгээх бүх шугам сүлжээнд үзлэг, засвар үйлчилгээг графикийн дагуу чанартай хийж, холбооны, цахилгааны шугам, хуваарилах байгууламжуудад гарч болзошгүй саатлыг багасгах арга хэмжээ авах

Дөрөв.Засаг даргын орлогч, аж ахуйн нэгжийн дарга, захирал, төсвийн шууд Захирагч нарт:

4.1.Сум, тосгоны Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба болон төсвийн байгууллагууд болон энэхүү албан даалгаварт нэр дурдагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, гүйцэтгэсэн ажлын тайланг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө, оруулалтын хэлтэст ирүүлсэн байх

Тав.Сумын Засаг даргын орлогчид:

5.1.Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Оюунгэрэл)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР